



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЛУУС СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 02 өдөр

Дугаар А/01

Цагаан-Овоо

Хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих жил
болгон зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.2, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, өөрийнхөө болон нийгмийн амьдралд залуучуудын оролцоог дээшлүүлэх, хүлээх хариуцлагыг дээшлүүлэх, амьдрах орчин, ээлтэй орчин бүрдүүлэх, чадварлаг бүтээлч ёс суртахуунтай боловсролтой соёлтой иргэн болж төлөвшүүлэх зорилгоор 2024 оныг “Хүүхэд,залуучуудын хөгжлийг дэмжих жил” болгон зарласугай.

2.“Хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих жил”-ийн ажлыг сумын хэмжээнд зохион байгуулах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

3.Сумын төсөвт байгууллагын удирдлага, багийн Засаг дарга нар жилийн ажлын төлөвлөгөөндөө тусган хэрэгжилтийг ханган ажиллахыг үүрэг болгосугай.

4.“Хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих жил”-ийн төлөвлөгөө хөтөлбөр боловсруулан батлуулж, удирдлага зохион байгуулалтаар хангаж, хэрэгжилт, үр дүнг тооцон сумын Засаг даргын зөвлөлийн хуралд тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Э.Энхжаргал)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ӨЛЗИЙХИШИГ

4824010001